



МОНГОЛ УЛС  
ХОВД АЙМГИЙН ЗАСАГ ДАРГЫН  
ЗАХИРАМЖ

2020 оны 06 сарын 09 өдөр

Дугаар А/317

Ховд

Хөрөнгө гаргах тухай


Төсвийн тухай Монгол Улсын хуулийн 14 дүгээр зүйлийн 14.2.3 дахь заалт, 41 дүгээр зүйлийн 41.2.2 дахь заалт, аймгийн Иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын 2019 оны 10/06 дугаар тогтоолыг тус тус үндэслэн ЗАХИРАМЖЛАХ нь:

1. Бүх сумдад Төрийн үйлчилгээний нэгдсэн системийг нэвтрүүлж хөдөөгийн иргэдэд төрийн 11 байгууллагын 54 үйлчилгээг эхний шатанд авах боломж бүхий Хур системийг нэвтрүүлэх, аймгийн Засаг даргын Тамгын газрын мэргэжилтнүүд, сумдын Засаг даргын Тамгын газрын хууль, эрх зүйн ажилтнуудыг сургалтад хамруулан дадлага эзэмшүүлж арга зүйн зөвлөгөө, хариуцлагын гэрээ байгуулж шаардлагатай тоног төхөөрөмжийг хүлээлгэн өгсөн сургалтын зардалд 6 000 000 төгрөг зарцуулсугай.

2. Дээрх арга хэмжээнүүдэд зарцуулах 6 000 000 төгрөг /Зургаан сая/-ийг аймгийн орон нутгийн хөгжлийн сангийн хөрөнгөөр 2020 онд хэрэгжүүлэх хөрөнгө оруулалт, хөтөлбөр, арга хэмжээний жагсаалтын 4.26-д заасан арга хэмжээнээс санхүүжүүлэхийг аймгийн Засаг даргын Тамгын газрын Санхүү, төрийн сангийн хэлтсийн дарга /Ч.Багдал/, Хөрөнгө оруулалт, хөгжлийн бодлого төлөвлөлтийн хэлтсийн дарга /Б.Баярсүх/ нарт зөвшөөрсүгэй.

3. Захирамжийн хэрэгжилтэнд хяналт тавьж ажиллахыг Засаг даргын орлогч /Т.Жаргалсайхан/-д даалгасугай.

ЗАСАГ ДАРГА



Б.ДҮГЭРЖАВ

Zax A/317 Ch